


БАТЛАВ: ТАМГИЙН ГАЗРЫН
ДАРГА  Ж.ДАВААХҮҮ



Даланзадгад

2018.03.26

Даланзадгад сумын услалтын системийг засварлаж, ашиглалтын
хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын даалгавар

Даланзадгад сумын Далан булгийн хөв цөөрмийг лайдах, халиагч засварлах ажил

Цөөрмийн хүчин чадал: 25500 м² ус хуримтлуулах

Даланзадгад сумын Далан булгийн цөөрөмд их хэмжээний үерийн ус хуримтлагдсанаас лай шавар ихсэн ус дамжуулах хоолой бөглөрч эвдэрсэн, сэтэрсэн халиагчийг засварлан ашиглалтад оруулах зорилгоор доорх ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд

- Далангийн цөөрөмд хуримтлагдсан лайг цэвэрлэн шугам сүлжээний бөглөрлийг арилган 200мм голчтой хоолойгоор ус дамжих боломжоор хангах,
- Далангийн илүүдэл ус халиагч сэтэрсэн тул засварлан даланг нягтруулан, шинээр төмөр бетон хийцтэй илүүдэл ус халиагч цутгах,
- Далангийн цөөрмийн гадна талын даланг нэгэн жигд хэлбэршүүлэн өндөрсгөн машин техник гаргах боломжгүй болгон харагдах байдлыг сайжруулах
- 3 метрийн өндөртэй, 18 метрийн урттай, 426 гийн диаметртэй 2 хаалт бүхий, гурван тулгууртай ус юүлэх бүрэн цутгамал байгууламж барих
- Цөөрмийг лайдах /8000-10000 м³ лаг шаврыг зөөж гаргах/
- Илүүдэл усжуулалтын 20 метр хос шугамыг худаг хүртэл лайдан, цэвэрлэн онгойлгоно
- Шаардлагатай тохиолдолд тус 20м хос шугамыг худаг хүртэл солино
- Лайдсан 6000м² талбайг хусаж, тэгшлэн дагтаршуулна.
- Лай асгах талбай / тоосгоны үйлдвэрийн урд нүх гарсан хэсгүүдийг бөглөж буулгах бөгөөд далангаас 6 км зайд байрлана/
- Цөөрмийн зүүн талын хуучин лайдсан шавар шороог тэгшлэх, зөөх
- Нээж хаадаг гаргуурын хоолойн бөглөөсийг гаргах